



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 80

Баруун-Урт

Аймгийн ИТХ-ын ээлжит 5 дугаар хуралдааны
төв зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.7 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн ИТХ-ын ээлжит 5 дугаар хуралдааныг 2017 оны 12 сарын 13-ны өдөр хуралдуулахаар товлосугай.

Хоёр. Хуралдаанаар хэлэлцэх асуудал

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны биелэлтийн тайлан
2. Аймгийн Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт
3. Аймгийн Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт
4. 2017 оны төсвийн тодотгол
5. 2016 оны төсвийн гүйцэтгэл, 2018 төсвийн төсөл

Гурав. Хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, холбогдох байгууллага, албан тушаалтнаас хэлэлцэх асуудлын материалыг авч хянан, намын бүлгүүдийн дарга наарт болон ИТХ-ын төлөөлөгч бүрт хэлэлцэх асуудлыг хүргэж ажиллахыг ИТХ-ын нарийн бичгийн дарга /А.Чулуунбат/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2017 оны 11 сарын 10-ны өдрийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 75 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.МӨНХБАТ

